АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Архангай аймгийн Цахир сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: АРА-2026/91/НА-СТА-ТШЗ**


| | |
|---|---|
| Цахим хуудас: www.open.audit.mn<br>Архангай аймаг<br>2026 он | Дарга,Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа<br>Утас:7033-3141<br>Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn<br>Аудитын менежер Д.Нэргүйбаатар<br>Утас: 7033-2860<br>Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn<br>Аудитыг гүйцэтгэсэн: Гроут финанс Аудит ХХК-ийн<br>Гүйцэтгэх захирал Б.Бямбадорж<br>Утас:77721628<br>Цахим хаяг: Byambadorj@growthfinance.mn |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2026.02.24 № 45
танай ____________-ны №____________-т

АРХАНГАЙ АЙМГИЙН ЦАХИР
СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
М.БАТСАЙХАН ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Цахир сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант онд Цахир сумын ерөнхий боловсролын сургууль нь 7,307,737.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсныг санхүүгийн тайланд тусгасан байна.

**Аудитын гол асуудал**

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх “Ерөнхий боловсрол” хөтөлбөрийн хүрээнд үндсэн үйл ажиллагааны 14 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,590,235.9 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрдүүлж, гүйцэтгэлээр 2,500,066.0 мянган төгрөг зарцуулсан байна.

**Бусад асуудлын хэсэг**

Тус байгууллага нь 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 8 үндсэн зорилтын хүрээнд 125 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР T.БАЙГАЛМАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* ( төгрөгөөр)

| Данс код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **346,255,889.36** | **219,212,595.30** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 216,261,733.52 | 45,746,178.38 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 216,261,733.52 | 45,746,178.38 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 216,261,733.52 | 45,746,178.38 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **129,994,155.84** | **173,466,416.92** |
| **351** | **Түүхий эд материал** | **78,158,530.00** | **83,619,445.00** |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 78,158,530.00 | 83,619,445.00 |
| **354** | **Хангамжийн материал** | **51,835,625.84** | **89,846,971.92** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 5,740,115.00 | 10,198,525.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 24,487,747.00 | 26,906,247.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 10,646,000.00 | 34,711,003.98 |
| 35450 | Барилгын засварын материал | 500,500.00 | 1,788,895.10 |
| 35460 | Хүнсний материал | 688,360.00 | 6,178,157.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 9,772,903.84 | 10,064,143.84 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **714,548,809.76** | **7,991,092,106.02** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 714,548,809.76 | 7,991,092,106.02 |
| **392** | **Биет хөрөнгө** | 680,395,059.76 | 7,957,652,856.02 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 702,912,040.00 | 6,078,590,612.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (336,453,723.71) | (350,119,441.66) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 292,409,146.00 | 379,659,793.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (85,336,978.73) | (156,762,691.33) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 72,346,604.14 | 255,182,761.14 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (27,964,731.08) | (40,566,295.47) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 41,639,680.00 | 1,748,541,108.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (18,819,840.36) | (22,983,808.44) |
| 39217 | Ном | 39,662,863.50 | 66,110,818.78 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 34,153,750.00 | 33,439,250.00 |
| 39301 | Програм хангамж | 4,500,000.00 | 4,632,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (1,406,250.00) | (2,252,750.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 31,060,000.00 | 31,060,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,060,804,699.12** | **8,210,304,701.32** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **-** | **9,424,450.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | - | 9,424,450.00 |
| **413** | **Өглөг** | - | 9,424,450.00 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | - | 6,034,870.00 |
| **4136** | **Бусад өглөг** | - | 3,389,580.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | - | 3,389,580.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,060,804,699.12** | **8,200,880,251.32** |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 1,060,804,699.12 | 8,200,880,251.32 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 498,336,056.68 | 498,336,056.68 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 511,938,845.28 | 7,652,014,397.48 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 511,938,845.28 | 511,938,845.28 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 7,140,075,552.20 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 50,529,797.16 | 50,529,797.16 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,060,804,699.12** | **8,210,304,701.32** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* ( төгрөгөөр)

| Дансны код | Балансын зүйл | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **2,171,091,785.24** | **9,678,172,973.28** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **108,752,385.24** | **7,311,621,773.28** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 108,752,385.24 | 7,311,621,773.28 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 108,752,385.24 | 7,311,621,773.28 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,415,300.00 | 422,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 315,000.00 | - |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 79,005,961.40 | 7,307,737,618.28 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 28,016,123.84 | 3,462,155.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,062,339,400.00** | **2,366,551,200.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,917,709,200.00 | 2,184,151,900.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,917,709,200.00 | 2,184,151,900.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 144,630,200.00 | 182,399,300.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 144,630,200.00 | 182,399,300.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **2,018,765,729.83** | **2,538,097,421.08** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,018,765,729.83** | **2,538,097,421.08** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,873,699,512.83 | 2,376,661,639.18 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,426,307,235.00 | 1,838,331,372.00 |
| 210101 | Үндсэн цалин | 848,317,654.00 | 1,054,274,587.00 |
| 210102 | Нэмэгдэл | 455,410,442.00 | 593,897,022.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 48,575,000.00 |
| 210104 | Урамшуулал | 122,579,139.00 | 141,584,763.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 178,921,685.22 | 226,675,291.94 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 122,207,584.79 | 156,125,734.56 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 14,365,753.28 | 18,380,836.60 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 7,466,818.07 | 9,215,934.40 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 7,014,061.62 | 8,605,042.94 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 27,867,467.46 | 34,347,743.44 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 68,620,608.00 | 87,352,636.32 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,744,908.00 | 31,111,527.00 |
| 210302 | Түлш, халаалт | 57,875,700.00 | 45,061,109.32 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,000,000.00 | 11,180,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 25,292,618.00 | 32,190,000.50 |
| 210502 | Хоол, хүнс | 25,292,618.00 | 32,190,000.50 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 12,605,685.00 | 2,706,900.00 |
| 210604 | Урсгал засвар | 12,605,685.00 | 2,706,900.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 16,687,135.64 | 23,399,121.70 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,415,300.00 | 1,500,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 15,271,835.64 | 21,899,121.70 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 145,264,545.97 | 166,006,316.72 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 33,470,314.44 | 52,124,572.70 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 16,210,156.00 | 10,965,906.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 95,584,075.53 | 102,915,838.02 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 145,066,217.00 | 161,435,781.90 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 93,654,250.00 | 124,012,990.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 62,315,650.00 | 91,830,090.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 31,338,600.00 | 32,182,900.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 51,411,967.00 | 37,422,791.90 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 51,411,967.00 | 37,422,791.90 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **152,326,055.41** | **7,140,075,552.20** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 17,342,405.98 | - |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 17,342,405.98 | - |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | (17,342,405.98) | - |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **134,983,649.43** | **7,140,075,552.20** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* ( төгрөгөөр)

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **2,064,069,700.00** | **2,366,973,200.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,730,300.00** | **422,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **1,730,300.00** | **422,000.00** |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **1,730,300.00** | **422,000.00** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,415,300.00 | 422,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 315,000.00 | - |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,062,339,400.00** | **2,366,551,200.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,917,709,200.00 | 2,184,151,900.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,917,709,200.00 | 2,184,151,900.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **144,630,200.00** | **182,399,300.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 144,630,200.00 | 182,399,300.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,932,900,135.86** | **2,465,767,239.14** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,932,900,135.86** | **2,465,767,239.14** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,787,064,568.86** | **2,304,271,647.24** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,426,307,235.00** | **1,837,016,772.00** |
| 210101 | Үндсэн цалин | 848,317,654.00 | 1,052,959,987.00 |
| 210102 | Нэмэгдэл | 455,410,442.00 | 593,897,022.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 48,575,000.00 |
| 210104 | Урамшуулал | 122,579,139.00 | 141,584,763.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **178,921,685.22** | **226,675,291.94** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 122,207,584.79 | 156,125,734.56 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 14,365,753.28 | 18,380,836.60 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 7,466,818.07 | 9,215,934.40 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 7,014,061.62 | 8,605,042.94 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 27,867,467.46 | 34,347,743.44 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **77,331,408.00** | **132,976,508.10** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,744,908.00 | 31,111,527.00 |
| 210302 | Түлш, халаалт | 65,915,500.00 | 90,244,981.10 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,671,000.00 | 11,620,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **24,736,760.00** | **34,019,767.50** |
| 210502 | Хоол, хүнс | 24,736,760.00 | 34,019,767.50 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **14,566,385.00** | **12,000,000.00** |
| 210604 | Урсгал засвар | 14,566,385.00 | 12,000,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **17,723,135.64** | **21,705,621.70** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,415,300.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 16,307,835.64 | 21,705,621.70 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **47,477,960.00** | **39,877,686.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 33,982,860.00 | 29,820,886.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 13,495,100.00 | 10,056,800.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **145,835,567.00** | **161,495,591.90** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **94,423,600.00** | **124,072,800.00** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 63,085,000.00 | 91,889,900.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 31,338,600.00 | 32,182,900.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **51,411,967.00** | **37,422,791.90** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 51,411,967.00 | 37,422,791.90 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **131,169,564.14** | **(98,794,039.14)** |
| **4** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)** | **-** | **-** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **49,714,440.00** | **71,721,516.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **49,714,440.00** | **71,721,516.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 49,714,440.00 | 71,721,516.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 49,714,440.00 | 71,721,516.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(49,714,440.00)** | **(71,721,516.00)** |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **-** | **-** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 81,455,124.14 | (170,515,555.14) |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **134,806,609.38** | **216,261,733.52** |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **216,261,733.52** | **45,746,178.38** |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* ( төгрөгөөр)

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл** | **498,336,056.68** | **51,904,631.16** | **375,580,361.85** | **925,821,049.69** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | 1,374,834.00 | 1,374,834.00 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | (1,374,834.00) | - | (1,374,834.00) |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **498,336,056.68** | **50,529,797.16** | **376,955,195.85** | **925,821,049.69** |
| Тайлант үеийн үр дүн | - | - | 134,983,649.43 | 134,983,649.43 |
| **2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл** | **498,336,056.68** | **50,529,797.16** | **511,938,845.28** | **1,060,804,699.12** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **498,336,056.68** | **50,529,797.16** | **511,938,845.28** | **1,060,804,699.12** |
| Тайлант үеийн үр дүн | - | - | 7,140,075,552.20 | 7,140,075,552.20 |
| **2025 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл** | **498,336,056.68** | **50,529,797.16** | **7,652,014,397.48** | **8,200,880,251.32** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* ( төгрөгөөр )

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 2,590,235,900.0 | 2,500,065,963.2 | 90,169,936.8 | 96.5 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 2,590,235,900.0 | 2,500,065,963.2 | 90,169,936.8 | 96.5 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 2,462,286,500.0 | 2,375,993,163.2 | 86,293,336.8 | 96.5 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,869,847,800.0 | 1,837,016,772.0 | 32,831,028.0 | 98.2 |
| 210101 | Үндсэн цалин | 1,124,504,000.0 | 1,052,959,987.0 | 71,544,013.0 | 93.6 |
| 210102 | Нэмэгдэл | 630,153,200.0 | 593,897,022.0 | 36,256,178.0 | 94.2 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 48,575,000.0 | (48,575,000.0) | - |
| 210104 | Урамшуулал | 115,190,600.0 | 141,584,763.0 | (26,394,163.0) | 122.9 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 233,730,900.0 | 226,675,291.9 | 7,055,608.1 | 97.0 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 158,937,100.0 | 156,125,734.6 | 2,811,365.4 | 98.2 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 18,698,500.0 | 18,380,836.6 | 317,663.4 | 98.3 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 9,349,200.0 | 9,215,934.4 | 133,265.6 | 98.6 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 9,349,200.0 | 8,605,042.9 | 744,157.1 | 92.0 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 37,396,900.0 | 34,347,743.4 | 3,049,156.6 | 91.8 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 170,399,300.0 | 132,976,508.1 | 37,422,791.9 | 78.0 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 31,900,000.0 | 31,111,527.0 | 788,473.0 | 97.5 |
| 210302 | Түлш, халаалт | 125,220,300.0 | 90,244,981.1 | 34,975,318.9 | 72.1 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 13,279,000.0 | 11,620,000.0 | 1,659,000.0 | 87.5 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | - | - | - | - |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2105** | **Нормативт зардал** | 34,494,800.0 | 34,019,767.5 | 475,032.5 | 98.6 |
| 210502 | Хоол, хүнс | 34,494,800.0 | 34,019,767.5 | 475,032.5 | 98.6 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 12,000,000.0 | 12,000,000.0 | - | 100.0 |
| 210604 | Урсгал засвар | 12,000,000.0 | 12,000,000.0 | - | 100.0 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 29,830,300.0 | 29,482,137.7 | 348,162.3 | 98.8 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 29,830,300.0 | 29,482,137.7 | 348,162.3 | 98.8 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 111,983,400.0 | 103,822,686.0 | 8,160,714.0 | 92.7 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 101,923,100.0 | 93,765,886.0 | 8,157,214.0 | 92.0 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 10,060,300.0 | 10,056,800.0 | 3,500.0 | 100.0 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 127,949,400.0 | 124,072,800.0 | 3,876,600.0 | 97.0 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 127,949,400.0 | 124,072,800.0 | 3,876,600.0 | 97.0 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 95,766,500.0 | 91,889,900.0 | 3,876,600.0 | 96.0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 32,182,900.0 | 32,182,900.0 | - | 100.0 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 2,590,235,900.0 | 2,329,550,408.1 | 261,107,491.9 | 89.9 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 2,200,432,000.0 | 2,184,151,900.0 | 12,682,600.0 | 99.4 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 2,200,432,000.0 | 2,184,151,900.0 | 12,682,600.0 | 99.4 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 182,399,300.0 | 144,976,508.1 | 37,422,791.9 | 79.5 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 182,399,300.0 | 144,976,508.1 | 37,422,791.9 | 79.5 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 207,404,200.0 | 422,000.0 | 211,002,100.0 | 0.2 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 422,000.0 | - | 422,000.0 | - |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 206,982,200.0 | - | 210,580,100.0 | - |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 216,261,733.5 | 216,261,733.5 | - | |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 216,261,733.5 | 45,746,178.4 | 170,515,555.1 | |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1.0 | 1.0 | - | 100.0 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1.0 | 1.0 | - | 100.0 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 59.0 | 59.0 | - | 100.0 |
| 620001 | Удирдах ажилтан | 4.0 | 4.0 | - | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 32.0 | 32.0 | - | 100.0 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 23.0 | 23.0 | - | 100.0 |
| **63** | **СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)** | 492.0 | 984.0 | (492.0) | 200.0 |
| **630** | **ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД** | 492.0 | 984.0 | (492.0) | 200.0 |
| 630001 | Төрийн өмчит ЕБС | 492.0 | 984.0 | (492.0) | 200.0 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар залруулаагүй нийт 10,446.1 мянган төгрөгийн зөрчил[1] илэрч 259.8 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, 10,186.3 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүллээ.

Аудитаар залруулагдаагүй 4 зөрчилтэй асуудлын материаллаг алдаа зөрчил нь 10,446.1 мянган төгрөг бөгөөд гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн 27,558.3 мянган төгрөгөөс бага байх тул **Өөрчлөлтгүй дүгнэлт** өглөө.

### 3.1 Төлбөрийн акт

3.1.1. Архангай аймгийн Боловсролын газрын даргын Б/21, А/45 тоот тушаалаар ур чадварын нэмэгдлийг тайлант жилийн 3–6, 9–12 дугаар саруудад олгосон бол 8 дугаар сард тушаалгүйгээр захиралд 155.9 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл олгосон байна.

Энэ нь "Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.6 ".харьяа дээд шатны албан тушаалтны зөвхөн хуульд нийцсэн шийдвэрийг биелүүлэх" мөн 'ЗГ-ын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт “Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам”-ын 2 “Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг тухайн байгууллагын төсвийн шууд захирагч шийдвэрлэнэ” гэсэн заалтыг зөрчиж байна.

*<u>Шийдвэрлэсэн нь</u>*: Төсөвт буцаан төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

3.1.2. Алба хаасан хугацааны нэмэгдэл 103,900 төгрөгөөр илүү бодож олгосон

Энэ нь "Төрийн хэмнэлтийн тухай" хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно": 15.1.3 "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", "Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.6 ".харьяа дээд шатны албан тушаалтны зөвхөн хуульд нийцсэн шийдвэрийг биелүүлэх" мөн 'ЗГ-ын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам" гэсэн заалтыг зөрчиж байна.

*<u>Шийдвэрлэсэн нь</u>*: Төсөвт буцаан төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

### 3.2 Албан шаардлага

3.2.1. "Балансын урамшуулал олгох тухай" тус сургуулийн 2025.09.25-ны өдрийн Б/36 дугаар тушаалыг үндэслэн "2024 санхүүгийн тайланд өөрчлөлтгүй дүгнэлт авсан гэсэн үндэслэлээр "улирлын үр дүнгийн урамшуулал"-тай давхардуулан "балансын урамшуулал" 2,664.0 мянган төгрөгийг олгосон нь хууль, журамд нийцэхгүй байна.

Энэ нь "Төрийн хэмнэлтийн тухай" хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно": 15.1.3 "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", "Төрийн албаны тухай" хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.Онцгой чухал буюу онц төвөгтэй албан даалгавар биелүүлсэн, байгууллагын үйл ажиллагаа, зохион байгуулалт, үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр шинэ санал, санаачилга гаргаж хэрэглээнд нэвтрүүлсэн болон бусад нөхцөл, шаардлагыг хангасан төрийн албан хаагчийг дараах хэлбэрээр шагнаж, урамшуулна: 51.1.4 "улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох" гэсэн заалтыг зөрчсөн байна.

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

*Шийдвэрлэсэн нь*: Зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх.

3.2.2. Багш ажилтнуудын гүйцэтгэлийн үнэлгээний урамшуулалд 32,182.9 мянган төгрөгийг 49 ажилтанд олгохдоо зөвхөн "Хувь хүний орлогын албан татвар" 10 хувь болох 3,218.3 мянган төгрөгийг суутгасан байх бөгөөд 7,522.3 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг суутган авч, төсөвт төлөөгүй байна.

Энэ нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 19 дугаар зүйлийн 19.1 “Даатгуулагч, ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл ногдох орлогын бүрэлдэхүүнд дараах цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг хамааруулна”: 19.1.1 "Хөдөлмөрийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.5 дахь хэсэг, 101 дүгээр зүйлийн 101.1 дэх хэсэг, 111, 112, 113, 114, 115, 116, 117 дугаар зүйлд тус тус заасан цалин хөлс, олговор"  гэсэн заалтыг зөрчсөн байна.

*Шийдвэрлэсэн нь*: Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Ур чадварын нэмэгдэл илүү олгосон | 1 | 155.9 | 1 | 155.9 | | | | |
| Удаан жилийн нэмэгдэл илүү олгосон | 1 | 103.9 | 1 | 103.9 | | | | |
| Балансын урамшуулал олгосон | 1 | 2,664.0 | | | 1 | 2,664.0 | | |
| НДШ суутган буюу ногдуулаагүй. | 1 | 7,522.3 | | | 1 | 7,522.3 | | |
| **Дүн** | **4** | **10,446.1** | **2** | **259.8** | **2** | **10,186.3** | **-** | **-** |